

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ МЭНДСАЙХАН ОВОГТОЙ ДАВААЖАВЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 07 дугаар сарын 22-ны өдөр

Нэр дэвшигч миний бие сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, мөн 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2015 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд тулгуурлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 37 дугаар зүйлийн хэсэгт нийцүүлэн боловсрууллаа.

ИРГЭНД ЭЭЛТЭЙ 8 ТАЛТ ХӨГЖИЛ

Нэг. Боловсрол:

- ✓ Боловсролын үйлчилгээний үр өгөөжтэй, тэгш, хүртээмжтэй, ээлтэй байдлыг хангах, амьдрах арга ухаантай, бүтээлч, оюунлаг иргэнийг төлөвшүүлэхэд дэмжин ажиллана.
- ✓ Сургуулийн өмнөх насны, ерөнхий боловсролын сургууль болон төсөл хөтөлбөрийн сургагч багш нарын ур чадварыг дээшлүүлэх талаар онцгой анхаарч тодорхой ажлыг зохион байгуулна.
- ✓ Төрийн залуу албан хаагчдын мэргэжил ур чадварыг дээшлүүлж сургалтад хамруулж чадваржуулна.

Хоёр. Соёл, спорт

- ✓ “Хүүхэд хөгжлийн” аян өрнүүлж, ёс заншил, түүх соёл, төрөлх нутаг, байгалиа хамгаалах, бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлнэ.
- ✓ Орон нутгийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг цахим хэлбэрт шилжүүлж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Оюуны болон багийн спортыг дэмжин ажиллаж, нийтийг хамарсан спортын арга хэмжээг өргөжүүлнэ.



000001

Гурав. Эрүүл мэнд


- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлж, мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй, хариуцлагатай, хүний нөөцийг төлөвшүүлэхийн тулд хамтран ажиллана.
- ✓ Иргэдийг жилд нэг удаа үнэ төлбөргүй эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.
- ✓ Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлж, архи, тамхины хэт их хэрэглээ зэрэг хүний зан үйлтэй холбоотой өвчлөлүүдээс сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд эмч, мэргэжилтэн, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг дээшлүүлнэ.
- ✓ Эмч,сувилагч болон эрүүл мэндийн байгууллагын ажилчдын ур чадвар, мэдлэг чадварыг сайжруулах, урт болон богино хугацааны сургалтад хамруулах ажлыг дэмжин ажиллана.

Дөрөв. Мал аж ахуй

- ✓ “Залуу малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөөгийн залуусаа дэмжинэ.
- ✓ Малын гаралтай түүхий эдээр ахуйн төвшинд үйлдвэрлэл эрхлэх төсөл хөтөлбөрийг дэмжинэ.
- ✓ Мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанарыг сайжруулан малын эрүүл мэндийг хамгаалах ажлыг өрнүүлнэ.
- ✓ Малын үржлийн ажилд биотехнологийн дэвшилтэт аргыг өргөн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ Бэлчээрийн талхигдлын талаар нарийн судалгаа хийж, хамгаалалтын менежмент боловсруулна.

Тав. Нийгмийн халамж, үйлчилгээ

- ✓ Нийгмийн халамж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэйгээр иргэдэд хүргэх зарчмыг баримтлан ажиллана.
- ✓ Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд хэрэгцээт үйлчилгээ авах нөхцөлйг төрийн болон бусад байгууллага бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.
- ✓ Ахмад настны мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх, ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг дэмжих үр дүнтэй хэлбэрээр ажлыг зохион байгуулна.





- ✓ Ахмад настныг амралт, рашаан сувилалд явуулах, чөлөөт цагийг нь зөв зохистой өнгөрөөх, тэднийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Ажилгүй, орлогогүй иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах ажлыг зохион байгуулна.

Зургаа. Бизнес эрхлэгчдийг дэмжих

- ✓ “Нутгийн бренд” бүтээгдэхүүнийг гаргаж зах зээлд гаргах боломж бүрдүүлнэ.
- ✓ Өрхийн аж үйлдвэрийг дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулж амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллана.
- ✓ Орон нутагт хэрэгжих төсөл хөтөлбөрийн мэдээллийг бизнес эрхлэгчдэд тэгш, хүртээмжтэй хүргэх, гарааны ижил боломж олгох ажлыг зохион байгуулна.
- ✓ Баялаг бүтээгчдийг хөдөлмөрийг үнэлж, шагнаж урамшуулахад анхаарна.

Долоо. Байгальд ээлтэй аялал жуулчлал

- ✓ Байгальд ээлтэй аялал жуулчлал дагасан үйлдвэрлэл үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.
- ✓ Аялагчдад зориулсан хог хаях хогийн цэгүүдийг байгуулна.
- ✓ Сумандаа “Байгальд ээлтэй аялал жуулчлал” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Найм. Сайн засаглалыг бэхжүүлэх

- ✓ Төрийн бодлого шийдвэр болон түүний хэрэгжилт нь хууль дүрмийн дагуу, тухайн шийдвэр үйл ажиллагаанд өртөж буй хүмүүст мэдээлэл ил тод байх зарчмыг баримтална.
- ✓ Төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг хүртээмжтэй, тэгш, хурдан шуурхай хүнд сурталгүй, авилгал ашиг сонирхлын зөрчилгүй байлгахад хяналтыг нэмэгдүүлнэ.
- ✓ Төрийн бодлого шийдвэрт иргэдийн оролцоог хангаж, саналыг тусгана.
- ✓ Орон нутгийн удирдлага хүлээсэн үүргээ шударгаар бүрэн дүүрэн гүйцэтгэхэд хяналтыг сайжруулан ажиллана.





БОЛОВСРУУЛСАН:



М.ДАВААЖАВ

/БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ/

Хаяг: Хөвсгөл аймаг, Шинэ-Идэр сум

Холбоо барих: 88104359, 93292939

Цахим шуудан: dawaajaw.mend@gmail.com

